

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 76 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Мезолитын үеийн үргэлжилсэн цаг хугацаа аль нь вэ? /1 оноо/
 - A. 800000-100000 жилийн өмнө
 - B. 12000-8000 жилийн өмнө
 - C. 8000-НТӨ III мянган
 - D. 40000-12000 жилийн өмнө
 - E. 100000-40000 жилийн өмнө
2. Мезолитын үеийн гол нээлт аль нь вэ? /2 оноо/
 - A. Урлагийн үүсэл
 - B. Жад
 - C. Нум сум
 - D. Гал
 - E. Чулуун зэвсэг
3. Хүснэгт доторх асуултын тэмдгийн оронд тохирох үгийг олоорой /1 оноо/

Үе	Дурсгал
Палеолит	Нарийн голын бууц суурин
Неолит	?

- A. Ярх уулын дархны газар
 - B. Тамсагбулагийн суурин
 - C. Мойлтын ам
 - D. Цагаан агуй
 - E. Оцон мааньт
4. Хүрлийн үе, түрүү төмрийн үеийн хүмүүс тахилга ба оршуулгын томоохон байгууламж босгодог байжээ. Ийм зориулалттай “Хиргисүүр” хэмээх байгууламж Монгол орны аль хэсгээр тархсан байдаг вэ? /1 оноо/
 - A. Баруун болон зүүн хэсгээр
 - B. Зүүн болон төв хэсгээр
 - C. Төв болон баруун хэсгээр
 - D. Зүүн болон хойд хэсгээр
 - E. Зүүн болон өмнөд хэсгээр
 5. Цэгийн оронд тохирох үгийг бичнэ үү
НТӨ II мянганд нүүдлийн мал аж ахуй бие даахтай зэрэгцэн технологийн бас нэгэн дэвшил гарсан нь.....байв. /1 оноо/
 - A. Ялтсан хутга
 - B. Чулуун зэвсэг
 - C. Зээтүү
 - D. Төмөр зэвсэг
 - E. Зүймэл зэвсэг
 6. Хань улс “Энх ургийн гэрээ”-г мөрдөхөөс татгалзаж Хүннүгийн эсрэг дайтах бодлогод хэдэн оноос шилжсэн бэ? /1 оноо/
 - A. НТӨ 141 он
 - B. НТӨ 176 он
 - C. НТӨ 133 он
 - D. НТӨ 198 он
 - E. НТӨ 121 он
 7. Хүннү гүрний үед холбогдох түүхэн үйл явдлуудыг зөв дараалалд оруулсан нь аль вэ? /2 оноо/
 1. “Энх ургийн гэрээ”-г байгуулав.
 2. Цинь улс мөхөж, Хань улс байгуулагдав.
 3. Хүннүгийн вангууд болох Сютү, Хүнье нар ялагдаж, Хань улсад бууж өгөв.
 - A. 2,3,1
 - B. 1,2,3
 - C. 3,2,1
 - D. 2,1,3
 - E. 1,3,2
 8. Сяньби улс задарсан 235 оныг зууны тоололд шилжүүлнэ үү /1 оноо/
 - A. III зууны II хагас
 - B. II зууны I хагас
 - C. III зууны I хагас
 - D. II зууны II хагас
 - E. I зууны I хагас
 9. Түрэгүүд Жужан улсад юугаар алба барьдаг байсан бэ? /1 оноо/
 - A. Давс
 - B. Мал
 - C. Торго
 - D. Ангийн арьс
 - E. Төмөр
 10. a,b жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? /1 оноо/
 - a. Гиюй, Таньшихуай, Шэлүн
 - b. Буман, Пэйло, Моюнчур
 - A. Хаан суусан цаг хугацааны их багаар
 - B. Монгол нутагт тогтсон төрт улсуудыг үндэслэн байгуулагчдаар
 - C. Монгол нутагт тогтсон төрт улсуудын хаадын угсаа гарвалын ялгаагаар
 - D. Гадагш хийсэн аян дайны цар хэмжээгээр
 - E. Эцэг хүүгийн холбоогоор



11. Хятад сурвалжийн мэдээнд “Хүннү, Сяньби нар мод, яс сийлэн тэмдэглэж хол ойрын хэрэг явдлаа хүмүүст улируулан уламжилсан нь түүхч, төрийн түшмэдийн тэмдэглэл мэт болсон” гэж өгүүлжээ. Энэ мэдээнд хийсэн дүгнэлтүүдээс аль нь оновчтой вэ? /1 оноо/
- A. Хүннү, Сяньби нар бичиг үсэгтэй байсан бөгөөд хэрэг явдлаа тэмдэглэн үлдээдэг байжээ.
 B. Хүннү, Сяньби нар мод сийлэхдээ гаргуун байжээ.
 C. Хүннү, Сяньби нар Хятадтай адил төрийн түшмэдтэй байжээ.
 D. Хүннү, Сяньби нарын төрийн түүхийг хятад түүхчид тусгайлан судалдаг байжээ.
 E. Хүннү, Сяньби нар мод, ясан сийлбэрээр алдартай байжээ.
12. Жужан улсад ямар шашин дэлгэрч улмаар төрийн шашин болсон бэ? /1 оноо/
- A. Бурхны шашин B. Исламын шашин C. Манихейн шашин
 D. Христийн шашин E. Үнэн алдартны шашин
13. Монгол-Татар хоёр ханлигуудын хоорондын зөрчлийн шалтгаан аль нь вэ? /1 оноо/
- A. Татарууд Монголчуудад дургуй байсан учраас
 B. Татарууд Монголчууд биш учраас
 C. Шашны зөрчлийн улмаас
 D. Мал маллахад тохиромжтой бэлчээр нутгийн төлөөх тэмцэл
 E. Татарууд хоёр хуваагдсан учраас
14. X-XII зууны Монгол улсын үндсэн нутаг аль нь вэ? /2 оноо/
- A. Онон, Хэрлэн, Туул гурван голын эхээр
 B. Хэрлэнгийн дунд урсгал, Сэлэнгэ голын саваар
 C. Туул, Орхон голын саваар
 D. Алтайн, Хангайн нурууг дамнан Эрчис гол хүртэлх нутаг
 E. Хөлөн, Буйр нуурын орчмоор
15. Монгол аймаг улсуудыг газар нутагтай нь тохируулна уу. /2 оноо/
- | | | |
|----------------|-----------------------------------|---------------|
| 1. Татар аймаг | a. Хөлөн, Буйр нуурын сав газраар | |
| 2. Хэрэйд улс | b. Цагаан хэрмийн хойгуур | |
| 3. Онгуд | c. Туул, Орхон голын савд | |
| A. 1b, 2c, 3a | B. 1c, 2a, 3b | C. 1a, 2b, 3c |
| D. 1a, 2c, 3b | E. 1c, 2b, 3a | |
16. Монгол улсыг довтлохоор зэхэж байсан Найман улсыг Чингис хаан хэдэн онд мөхөөн дагуулсан бэ? /1 оноо/
- A. 1202 он B. 1201 он C. 1206 он D. 1203 он E. 1204 он
17. Их Монгол улсын том түмний ноёдыг түмэнтэй нь зөв тохируулсныг олно уу. /1 оноо/
- A. Баруун түмэн-Мухулай, Төвийн түмэн-Боорчи, Зүүн түмэн-Хорчи, Ойн түмэн-Наяа
 B. Баруун түмэн-Наяа, Төвийн түмэн-Боорчи, Зүүн түмэн-Хорчи, Ойн түмэн-Мухулай
 C. Баруун түмэн-Хорчи, Төвийн түмэн-Мухулай, Зүүн түмэн-Боорчи, Ойн түмэн-Наяа
 D. Баруун түмэн-Боорчи, Төвийн түмэн-Наяа, Зүүн түмэн-Мухулай, Ойн түмэн-Хорчи
 E. Баруун түмэн-Боорчи, Төвийн түмэн-Мухулай, Зүүн түмэн-Наяа, Ойн түмэн-Хорчи
18. Монголын Ил хаант улсын нийслэлийг сонгоно уу. /1 оноо/
- A. Сарай B. Дайду C. Марага D. Алмалиг E. Аксу
19. Монголын Цагадайн улсын газар нутгийг зөв тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/
- A. Эрчис мөрөн, Дунай мөрний доод урсгал, Кавказын нуруу
 B. Или голын сав, Долоон гол, Кашгарын нутаг буюу хуучин Хар Хятан
 C. Хятад, Солонгос, Өмнөд Азийн орнууд
 D. Армян, Гүрж, Турк, Афганистаны баруун хэсэг
 E. Иран, Ирак, Сирийн хойд хэсэг



20. Монголын төр хэзээ Хятад газраас эх нутагтаа эргэн ирсэн бэ? /1 оноо/
 А. 1378 он В. 1374 он С. 1368 он D. 1388 он E. 1380 он
21. Батмөнх даян хааны үеийг сурвалжид “Гар газар, хөл хөсөр болов” гэж тэмдэглэсний учир юу вэ? /2 оноо/
 А. Монголын дотоодын тэмцэл улам гүнзгийрч байсан үе
 В. Монголд шарын шашин дэлгэрсэн үе
 С. Мин улсын довтолгоо эрчимжиж байсан үе
 D. Монголын дотоодын хямрал нэг хэсэгтээ зогссон үе
 E. Тухайн үеийн нийгмийн амьдрал илүү хямралд орсон үе
22. XV-XVI зууны үеийн Зүүн Монголын жононгийн шууд захиргаанд байдаг, баруун гурван түмэнг зөв ялгасан хувилбар аль нь вэ? /2 оноо/
 1. Цахар 2. Ордос 3. Түмэд 4. Халх 5. Урианхай 6. Юншээбу
 А. 2, 3, 6 В. 2, 4, 5 С. 1, 4, 5 D. 1, 2, 3 E. 4, 5, 6
23. Батмөнх даян хааны үед Халх түмэн нь Арын 7 отог, Өврийн 5 отгоос бүрдэж байсан ба Өврийн 5 отгийг түүний хөвгүүдээс хэн нь өвлөн захирч байсан бэ? /1 оноо/
 А. Боди-Алаг В. Гэрсэнз С. Агваржин D. Алчуболд E. Гүнбилэг
24. **Далай лам:** Өдгөө Шарын шашны тэргүүнээр XIV Далай лам Данзанжамц заларч буй бөгөөд 1989 онд Нобелийн энх тайвны шагнал хүртсэн юм. Далай ламын бүх дүр Монголын түүхтэй ямар нэгэн сэжмээр холбогддог билээ. Монголоос тодруулсан IV Далай лам хэний гэрт мэндэлсэн бэ? /1 оноо/
 А. Гэрсэнз В. Алтан хан С. Сүмир хунтайж
 D. Абтай сайн хан E. Хутагтай сэцэн хунтайж
25. Эрдэнэ зуу хийдийг хэн, хэзээ байгуулсан бэ? /2 оноо/
 А. 1577 онд Алтан хан В. 1586 онд Абтай сайн хан С. 1592 онд Нэйж тойн
 D. 1748 онд Агваанжамбалданзан E. 1648 онд Зая бандида Намхайжамц
26. Дараах ойлголтуудыг утгаар нь зөв тохируулсныг сонгоорой. /2 оноо/
 1. Соёмбо үсэг а. Намхайжамц
 2. Али гали үсэг b. 1587 он
 3. Тод үсэг c. Занабазар
 А. 1с, 2а, 3b В. 1с, 2b, 3а С. 1а, 2b, 3с
 D. 1b, 2с, 3а E. 1а, 2с, 3b
27. 1636 онд Өвөр Монголын ноёдын чуулган хаана, хэнийг Өвөр Монголын хаанд өргөмжилсөн бэ? /1 оноо/
 А. Долоон нуурт Энх-Амгаланг В. Мүгдэнд Абахайг С. Бээжинд Абахайг
 D. Бээжинд Нурхачийг E. Хөх нуурт Энх-Амгаланг
28. 1638 онд Манжийн хаан Халхын 3 ханыг жил бүр ямар алба барьж, байх зарлиг буулгасан бэ? /2 оноо/
 А. Малаар алба хаах В. Ангийн үсний алба С. Өртөөний алба
 D. Харуулын алба E. 9 цагааны алба
29. Манж-Оросын “Нэрчү”-гийн гэрээгээр Орос улс Эрхүү, Түнхэний шивээ орчмын нутгийг хүн амын хамт харьяандаа оруулжээ. Уг гэрээ хэдэн онд болсон бэ? /1 оноо/
 А. 1681 онд В. 1727 онд С. 1607 онд D. 1771 онд E. 1689 онд
30. 1617 онд Авга хар ууланд Цагаан хотыг байгуулсан хаан хэн бэ? /1 оноо/
 А. Буян сэцэн хаан В. Аюук хаан С. Галдан хаан
 D. Цэвээнравдан хаан E. Лигдэн хаан
31. XVII-XVIII зуунд Монгол улс тусгаар тогтнолоо алдсан гадаад шалтгаануудаас аль нь **ИЛҮҮЦ** вэ? /2 оноо/
 А. Монголын их хааны сүр хүч буурсан учир
 В. Мин улсын хагалган бутаргах бодлого
 С. Хойд талаас Орос улсын түрэмгийлэл
 D. Мин улсын Монголын ноёдыг дэмжих бодлого
 E. Зүүн урдаас Хойт Алтан улсын заналхийлэл



32. 1723 онд болсон Хөхнуур, Төвөдийн бие даасан байдлыг хадгалахын төлөө Лувсанданзан тэргүүтэй ноёдын бослого Зүүн гарын хаант улсаас тусламж авч чадаагүй гол шалтгаан аль нь вэ ? /1 оноо/
- Цэвээнравдан хаантай дайсагнасан харилцаатай байсан тул
 - Төвөдийн ноёд Лувсанданзанг дэмжээгүй
 - Халхын II Богд Жавзандамба хутагт туслаагүй
 - Олон ноёд харьяатаа авч Манжид урвасан.
 - Энгийн ард олон дэмжиж оролцоогүй
33. Монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл хөдөлгөөнүүдийг он цагийн зөв дараалалд оруулсан хариултыг сонгоно уу. /2 оноо/
- Тогтох тайжийн удирдсан бослого
 - Лувсанданзангийн удирдсан бослого
 - Онолтын удирдсан бослого
- 3, 1, 2
 - 1, 2, 3
 - 3, 2, 1
 - 2, 1, 3
 - 2, 3, 1
34. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхэн ач холбогдол аль нь вэ? /1 оноо/
- Манжийн төрийн хуулийг дагаж мөрдөхөө больсон.
 - Манжийн амбан сайдыг хөөн гаргасан.
 - Манжийн алба татвараас чөлөөлөгдсөн.
 - Манжийн эрхшээлээс гарч тусгаар тогтнолоо сэргээсэн.
 - Хятад худалдаачдын тоо багассан.
35. 1913 онд “Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон чулуун нүүрсний орлогын хэдэн хувийг татварлах болсон бэ? /1 оноо/
- 10-20%
 - 10-15%
 - 5-10%
 - 20-50%
 - 30-50%
36. Дээд, доод танхим бүхий Улсын хурлыг хэдэн онд байгуулсан бэ? /1 оноо/
- 1918 онд
 - 1911 онд
 - 1913 онд
 - 1914 онд
 - 1919 онд
37. 1911 онд Монголчууд тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан билээ. Уг оныг билгийн тоололд шилжүүлнэ үү? /2 оноо/
- Доорх өгөгдлийг ашиглаж бодоорой.

Аргын оныг билгийн жилд шилжүүлэх арга	Махбодь жил	Гал	Шороо	Төмөр	Ус	Мод
Аргын оныг билгийн жилд шилжүүлэхдээ тухайн аргын оноос 1026-г хасч, гарсан ялгаврыг 60-д хуваасны бүхэл үлдэгдэл нь олох билгийн жилийн дугаар бөгөөд ноогдвор дээр 1-ийг нэмбэл олох билгийн жилийг харьяалах жарны дугаар гарна. Хүснэгтэд буй дугаараар билгийн жил хийгээд түүний махбодыг олно.	Туулай	1	13	25	37	49
	Луу	50	2	14	26	38
	Могой	51	3	15	27	39
	Морь	40	52	4	16	28
	Хонь	41	53	5	17	29
	Бич	30	42	54	6	18
	Тахиа	31	43	55	7	19
	Нохой	20	32	44	56	8
	Гахай	21	33	45	57	9
	Хулгана	10	22	34	46	58
	Үхэр	11	23	35	47	59
	Бар	60	12	24	36	48

- XV жарны модон бар жил
- XVI жарны шороон тахиа жил
- XIV жарны модон гахай жил
- XVII жарны шороон бич жил
- XV жарны төмөр гахай жил



38. Ардын засгийн газрын бүтцийг зөв тохируулсан нь аль вэ? /2 оноо/
 А. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-Х.Чойбалсан, Сангийн яам- Д.Догсом
 В. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-С.Данзан, Сангийн яам- Д.Пунцагдорж
 С. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-Н.Магсаржав, Сангийн яам- Д.Сүхбаатар
 D. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-Д.Пунцагдорж, Сангийн яам- С.Данзан
 E. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-Д.Лосол, Сангийн яам- Д.Чагдаржав
39. Ардын засгийн газрын анхны бага сургууль хэдэн онд байгуулагдсан бэ? /1 оноо/
 А. 1921 он В. 1923 он С. 1925 он D. 1924 он E. 1922 он
40. Монгол, Зөвлөлт Орос Улс хоёрын 1921.11.05-ны өдөр байгуулсан гэрээний агуулга аль нь вэ? /2 оноо/
 А. Эзэн хамжлагын харилцааг халах тухай
 В. Цагаантны үлдэгдлийн эсрэг цэргийн ажиллагааг үргэлжлүүлэх тухай
 С. Хятадын эсрэг эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай
 D. Хоёр улс засгийн газруудаа харилцан хүлээн зөвшөөрч, бүрэн эрхт төлөөлөгч суулгах тухай
 E. Тангарагийн гэрээг батлан мөрдүүлэх тухай
41. VIII Богд хаан хэдэн онд таалал төгссөн бэ? /1 оноо/
 А. 1921 он В. 1928 он С. 1926 он D. 1923 он E. 1924 он
42. 1922 оны 05 дугаар 29-нд байгуулагдсан Үндсэн хууль боловсруулах комиссын гишүүдийг олно уу. /1 оноо/
 А. Ж.Цэвээн, Д.Догсом В. Б.Цэрэндорж, Ч.Дамбадорж
 С. Х.Чойбалсан, Д.Лосол D. Ж.Цэвээн, Ч.Бат-Очир
 E. Догсом, Х.Чойбалсан.
43. 1932 оны 06-р сарын 29-30 хуралдсан МАХН-ын ТХ, хянан байцаах Төв Комиссын хамтарсан III бүгд хурлаар баталсан “Шинэ эргэлтийн бодлого”-ын ерөнхий агуулга аль вэ? /1 оноо/
 А. Зүүнтний алдаатай бодлогын уршгаар бий болсон сөрөг үр дагаварыг засах
 В. Эдийн засгийг сэргээн хөгжүүлэх
 С. Төрийн байгууламжийг өөрчлөх
 D. Улс орны батлан хамгаалах хүчийг нэмэгдүүлэх
 E. Төр намын байгуулгыг урвагчдаас цэвэрлэх
44. Зүүнтний алдаатай бодлогоор 16.3 сая болтол хорогдсон мал сүрэг 1940 он гэхэд хэд болж өссөн бэ? /2 оноо/
 А. 30 сая В. 20 сая С. 25 сая D. 26 сая E. 31 сая
45. 1936 оны 3-р сарын 12-нд БНМАУ, ЗСБНХУ-н хооронд “Харилцан туслалцах Протокол”-ыг Улаанбаатар хотноо байгуулжээ. Уг “Протокол”-ын гол агуулга аль нь вэ? /1 оноо/
 А. Хоёр улс хамтран Хятадын эсрэг довтолох
 В. Эдийн засгийн салбарт хамтран ажиллах
 С. Японд довтолж түүний түрэмгийллийг зогсоох
 D. Хоёр улсын хилийг шинээр тогтоох
 E. Гурав дахь этгээд хэн нэгэнд нь халдан довтолбол харилцан туслалцах
46. Атрын анхдугаар аян хэдэн оноос эхэлсэн бэ? /1 оноо/
 А. 2008 он В. 1961 он С. 1976 он D. 1959 он E. 1982 он
47. БНМАУ, 1963 онд Австри улстай дипломат харилцаа тогтоожээ. Энэ онд дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой болох вэ? /2 оноо/
 А. 50 жилийн ой
 В. 61 жилийн ой
 С. 60 жилийн ой
 D. 51 жилийн ой
 E. 59 жилийн ой



48. БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосон улс орнуудын он цагийг зөв тохируулсныг сонгоорой. /2 оноо/
- | | |
|-----------|------------|
| 1. Австри | a. 1965 он |
| 2. Франц | b. 1974 он |
| 3. ХБНГУ | c. 1963 он |
- A. 1b, 2a, 3c
B. 1c, 2b, 3a
C. 1b, 2c, 3a
D. 1c, 2a, 3b
E. 1a, 2c, 3b
49. Ховд дахь Багшийн Дээд сургуулийн хэсэг залуу багш оюутнууд Монголд анх удаа олон нийтийг хамарсан жагсаалыг хэзээ зохион байгуулсан бэ? /1 оноо/
- A. 1990 оны 03 сарын 07
B. 1989 оны 12 сарын 09
C. 1990 оны 02 сарын 18
D. 1990 оны 01 сарын 21
E. 1989 оны 12 сарын 07
50. Ардчилсан хүчнийхэн 1990.03.08-ны орой мэдэгдэл гаргахдаа ямар шаардлагыг гол болгож тавьсан бэ? /2 оноо/
- A. МАХН-ын үйл ажиллагааг зогсоох
B. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоог огцруулах
C. МАХН-ын аппаратыг төрийн ордноос гаргах
D. МАХН-ын түүхийг үнэн бодитой шинэчлэн боловсруулах
E. МАХН-ын үйл ажиллагааг төрөөс ангид байлгах
51. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу.
1992 оны Үндсэн хуулиар Ардчилал, хууль ёсыг хамгаалах дээд байгуулга хэмээх цоо шинэ байгуулгыг бий болгов. /1 оноо/
- A. Авилгалтай тэмцэх газар
B. Үндсэн хуулийн Цэц
C. Хүний эрхийн үндэсний комисс
D. Тагнуулын ерөнхий газар
E. Хууль зүй дотоод хэргийн яам
52. 1992 оны Үндсэн хуулийн дагуу явагдсан Монгол улсын Ерөнхийлөгчийн анхны сонгуульд хэн, хэн өрсөлдсөн бэ? /1 оноо/
- A. П.Очирбат, Д.Батбилэг
B. Л.Түдэв, П.Очирбат
C. П.Очирбат, Э.Бат-Үүл
D. Н.Багабанди, Л.Түдэв
E. Н.Багабанди, С.Зориг
53. Хэдэн онд “Монголын нууц товчоо” зохиогдсоны 750 жилийн ойг тэмдэглэсэн бэ? /1 оноо/
- A. 1995 онд B. 1990 онд C. 1994 онд D. 1980 онд E. 1985 онд
54. Ардчилсан хувьсгал гарснаас хойш эзэн богд Чингис хаанаа дээдлэн сүслэх болж, төрийн ордны өмнө ямар хаадуудын хөшөөг сүндэрлүүлсэн бэ? /2 оноо/
- A. Чингис, Өгэдэй, Хубилай
B. Чингис, Өгэдэй, Гүюг
C. Чингис, Гүюг, Хубилай
D. Чингис, Мөнх, Хубилай
E. Чингис, Гүюг, Мөнх



55. 2002 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлог үйл явдал аль нь вэ?

/1 оноо/

- A. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав.
- B. Японы ерөнхий сайд Тошкү Кайфу айлчлав.
- C. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав.
- D. ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин айлчлав.
- E. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн К.Аннан айлчлав.

56. Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын аль чиглэлд хамаарах вэ?

/1 оноо/

- A. Хүний аюулгүй байдлыг хангах
- B. Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах
- C. Дотоод аюулгүй байдлыг хангах
- D. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах
- E. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо

2.1 Монголын өвөг түүхийн үед холбогдох нээлтүүдийг хамрах үетэй нь зөв тохируулахдаа 1-7 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. /1 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/ /6 оноо/

- | | |
|---------------------------|---------------------------|
| a. Палеолитын доод үе | 1. Нум сум |
| b. Палеолитын дунд үе | 2. Нүүдлийн мал аж ахуй |
| c. Палеолитын дээд үе | 3. Гоёл чимэглэл |
| d. Мезолит | 4. Үлдэц цуулдас |
| e. Неолит | 5. Үйлдвэрлэх аж ахуй |
| f. Хүрэл төмрийн түрүү үе | 6. Зүймэл зэвсэг буюу жад |
| | 7. Төмөр дөрөө |

2.2 Монголын бүрэлдэхүүн улсуудын хаадыг зөв харгалзуулна уу. /6 оноо/

- | | |
|-----------------|--------------------|
| a. Хубилай | 1. Газан |
| b. Хүлэгү | 2. Ил хаант улс |
| c. Бат | 3. Цагайдайн улс |
| d. Юань улс | 4. Тогоонтөмөр |
| e. Цагадай | 5. Алтан ордны улс |
| f. Ил хаант улс | 6. Юань улс |

2.3 Монголын хаант улсуудын үеийн түүхэн зүтгэлтнүүдийг хамаарах ойлголттой нь зөв харгалзуулна уу. /6 оноо/

- | | |
|-------------------------|--------------------------------------|
| a. Лигдэн хаан | 1. Цорос аймгийн толгойлогч |
| b. Шолой Уваш | 2. Алтан ургийн сүүлчийн хаан |
| c. Галдан бошогт | 3. Хошуудын хаант улсыг байгуулсан. |
| d. Төрбайх Гүүш хан | 4. Халхын томоохон язгууртан |
| e. Цогт хунтайж | 5. Хотгойдын улсыг байгуулсан хүн |
| f. Эрдэнэбаатар хунтайж | 6. Зүүнгарын хаант улсыг байгуулсан. |

2.4 1921 оны хувьсгалын түүхэн гол үйл явдлуудыг зөв харгалзуулна уу. /6 оноо/

- | | |
|-------------------------|---|
| a. 1921 оны 2 сар | 1. Ардын түр засгийн газар МАН-ын ТХ-ны хамтарсан хурлаас Нийслэл хүрээг чөлөөлөх шийдвэр гаргав. |
| b. 1921 оны 3 сарын 1-3 | 2. Дээд Шивээнд /Тройцкосавскд/ эрмэлзэх 10-н зүйлийг батлав. |
| c. 1921 оны 03 сарын 17 | 3. Барон Унгерн Нийслэл хүрээг эзлэн авав. |
| d. 1921 оны 06 сарын 28 | 4. Сүхбаатарыг цэргийн жанжнаар томилов. |
| e. 1921 оны 02 сарын 04 | 5. Хиагтад байгаа гамин цэрэгт шаардах бичиг өгөв. |
| f. 1921 оны 07 сарын 10 | 6. Засгийн эрх шилжүүлэх ёслол болж Ардын засгийн газар байгуулагдав. |

